

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023
оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 14:40
дугаар тушаалын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

14:40

Байгууллагын нэр:

Экологийн цагдаагийн алба

Албан тушаалын нэр:

Дэд бөгөөд Дүн шинжилгээ, хяналт
шалгалтын хэлтсийн дарга

Ажлын цаг:

8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэс

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-2

Ажлын байрны албан ёсны байршил:

Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо,
Эрхүүгийн гудамж-6

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц
халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад
аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй
байдал үүссэн, террорист халдлага, онц
болон дайны байдал зарласан, онц ноцтой
гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй
тохиолдолд уртасгасан цагаар болон
өндержүүлсэн бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

- Монгол Улсын хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд Экологийн цагдаагийн алба, Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсээс хэрэгжүүлэх чиг үүрэг, гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах ажиллагааг мэргэжлийн удирдлага, арга зүйн дагуу удирдан зохион байгуулж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр ханганд, байгууллага, алба хаагч, ажилтны үйл ажиллагаанд хяналт тавих.
- Байгууллага, алба хаагч бусад ажиллагасдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх ажилд бүх талын туслалцаа үзүүлэх.

Албан тушаалын зорилт:

- Хууль тогтоомжийн хүрээнд алба, Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийн үндсэн чиг үүрэг, бодлогыг тодорхойлох ажлыг зохион байгуулах, хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх;

- 2.Хариуцсан чиглэлийн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх зорилтыг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар ханган, алба хаагчдын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, цагдаагийн байгууллагын гүйцэтгэх алба, алба хаагчдын ажлын уялдаа, холбоог сайжруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах;
- 3.Экологийн цагдаагийн албаны гүйцэтгэх болон мөрдөн шалгах ажиллагааг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган, хэрэг буртгэлт, мөрдөн шалгах ажлын явц, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээг төлөвлөн боловсруулах ажлыг удирдан зохион байгуулж, албаны даргад танилцуулах;
- 4.Албаны нууцын зэрэглэлтэй болон энгийн баримт бичиг няглан шалгах комиссын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих;
- 5.Байгууллагын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээллийг шалган, шийдвэрлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 6.Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх чиглэлээр заавар, зөвлөмж хүргүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах;
- 7.Зохион байгуулалтын бутцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, алба хаагчдын сахилга, ёс зүйн байдалд хяналт тавих;
- 8.Албаны нэгжүүдийн ажлын мэдээ, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- 9.Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1.Алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, үр чадварын түвшнийг дээшлүүлэх, сургалт, соён гэгээрүүлэх ажил, биеийн тамир спортын арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;</p> <p>1.2.Албаны даргын эзгүйд албан тушаалын үүргийг түр орлон гүйцэтгэх;</p> <p>1.3.Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр улсын хэмжээнд бодлого, стратеги төлөвлөгөө боловсруулан, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж, биелэлт үр дүнг тооцон, хяналт тавих;</p> <p>1.4. Алба хаагч, ажилтны эрх ашгийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх чиглэлээр ажил, арга хэмжээг зохион байгуулахад мэргэжлийн удирдлагаар ханган, дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэстэй хамтран ажиллах.</p>	Зорилт чиг үүргийн дагуу төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байна.	Г, Х Г, Х, Ш Х, Ш Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын холбогдох үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавин үр дүнг тооцох;	Хуулийн хэрэгжилт, нууцлал, аюулгүй байдал хангагдсан байна.	Х, Ш

	2.2.Гэмт хэрэгтэй тэмцэхэд мэргэжлийн байгууллагуудтай мэдээлэл солилцох, эрх бүхий байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах.		Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Удирдлагын шийдвэр, өгсөн үүрэг, ажлын чиглэлийн хэрэгжүүлэх ажлыг холбогдох газар, хэлтэс, алба хаагчаар гүйцэтгүүлэн биелэлт үр дүнг тооцох; 3.2.Гүйцэтгэх ажлын мэдээнд дун шинжилгээ хийн үнэлэлт, дүгнэлт өгч албаны даргад танилцуулах; 3.3.Тус албаны мөрдөн шалгах болон зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах; 3.4.Мөрдөн шалгах болон зөрчил шалган шийдвэрлэх нэгжийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, явц үр дүнг албаны даргад танилцуулж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 3.5.Мөрдөн шалгах болон мөрдөн шалгах нууц ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах хяналт тавьж ажиллах.	Хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангагдана.	Х, Ш Х, Ш Г, Х, Ш Х
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1.Албаны нууцын зэрэглэлтэй болон энгийн баримт бичиг нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг удирдан, комиссыг хуралдуулж, шийдвэр гаргах. 4.2.Үйл ажиллагааны явцад үүссэн нууцын зэрэглэлтэй болон энгийн баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын хадгаламжийн нэгж болгон бүрдүүлж байгаа эсэхэд хяналт тавих; 4.3.Нууцын зэрэглэлтэй болон энгийн архивын хадгаламжийн нэгжийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих.	Албаны нууцлал, аюулгүй байдал хангагдсан байна	Х, Ш Х Г, Х
5 дугаар зорилтын хүрээнд	5.1.Батлагдсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, үнэлэлт дүгнэлт өгч, удирдлагыг мэдээллээр хангах; 5.2.Албаны үйл ажиллагаа алба хаагчийн сахилга, ёс зүйн зөрчлийн талаар гаргасан өргөдөл, гомдолд холбогдох журмын дагуу дотоод хяналт шалгалт зохион байгуулах, энэ чиглэлээр хяналт шалгалт аюулгүй байдал хариуцсан алба хаагч бусад албан тушаалтанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх; 5.3.Гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдол эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэх явцад ирүүлсэн прокурорын шаардлага болон албан бичгийг нэгтгэн дун шинжилгээ хийж,	Албаны үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдэнэ	Х,Ш Х,Ш Х,Ш

	зөвлөмж, зааварчилгаагаар хангахад хяналт тавих.		
6 дугаар зорилтын хүрээнд	6.1. Байгууллагын хэмжээнд учирч болох эрсдэлийг зөв оновчтой тодорхойлон, эрсдэлийг бууруулах чиглэлээр албаны бүтцийн нэгжүүдэд ажлын чиглэл, зөвлөмж хүргүүлж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх.; 6.2. Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгийг ахалж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-113/-ын хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах,	Байгууллагын дотоод аюулгүй байдал хангагдана.	X,Ш
7 дугаар зорилтын хүрээнд	7.1.Хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд үндэслэн зөвлөмж боловсруулж хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих; 7.2.Алба хаагчийн гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд үнэлэлт дүгнэлт өгч, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр үүрэг, ажлын чиглэл хүргүүлж биелэлт, үр дүнг тооцох; 7.3.Сахилга, ёс зүйн зөвлөгөөнийг удирдан зохион байгуулахад хяналт тавих, алба хаагчдын сахилга, хариуцлагын талаарх мэдээллийг танилцуулах, үүрэг, чиглэл өгөх.	Алба хаагчдын сахилга, ёс зүй дээшилнэ.	X,Ш
8 дугаар зорилтын хүрээнд	8.1.Статистик мэдээнд тулгуурлан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, бүртгэгдсэн гомдол мэдээлэл, хэргийн шийдвэрлэлтийн талаар удирдлагыг мэдээллээр хангах.	Гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтэд ахиц гарна.	X,Ш
9 дүгээр зорилтын хүрээнд	9.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж байгууллагын ажилтнууд болон харилцагч үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх; 9.2.Авлига хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх; 9.3.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.	Цагдаагийн алба хаагчийн нийтлэг үүрэг, хууль тогтоомжоор хүлээлгэсэн бусад үүргийн биелэлт хангагдана.	Г Г Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	Эрх зүй /0421/


Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.	
Туршлага	Цагдаагийн байгууллагад 12-оос доошгүй жил ажилласан, үүнээс чиглэлийн ахлах, хэсэг, тасгийн дарга түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-Хариуцсан нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж, шаардлага тавьж чаддаг байх; -Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах; -Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх.
	Дүн шинжилгээ хийх	-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх; -Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж шийдлийн хувилбарын талаар зөвлөх.
	Асуудал шийдвэрлэх	-Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцуулэн гүйцэтгэх.
	Манлайлах	-Ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; -Байгууллагын үйл ажиллагааны шинэгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх.
	Бусад	-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, Монгол хэл, бичгийн дүрэм, уг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх; -Компьютерын Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх; -Нууц хадгалах.

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:
Экологийн цагдаагийн албаны дарга

Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: Шууд харилцах байгууллага: -Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан; Шууд бус харилцах байгууллага: -Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.
-----------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  Т.ГАНЗОРИГ 2023 оны 2 дугаар сарын 25-ны өдөр	Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:.....
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-өдөр

Дугаар: 4/401

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Т.СҮХБОЛД

ТАНИЛЦСАН:

Албан тушаалтан:

20...оны дугаар сарын-ны өдөр